

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО” ДАХЬ «-ТАI» БҮТЭЭВЭР ХИЙГЭЭД
ХУВИЛБАРУУДЫН ХЭЛЗҮЙН ХАРЬЦАА

Ц. Отгонсүрэн¹

Түлхүүр үгс: «-ТАI» бүтээвэр, хувилбар, өгүүлбэр дэх байр, утга, үүрэг

Оршил.

А. Монгол хэлний «-ТАI» бүтээврийг судалсан тухай:

Эл өгүүлэлд дурдах «-ТАI» бүтээврийг орчин цагийн монгол хэлнээ «хамтрахын тийн ялгалын нөхцөл» гэдэг ч угтаа эл нэр томъёоны хувьд өдгөө монгол хэлшинжлэлийн маргаантай асуудлын нэг, өөрөөр хэлбэл энэ мэт залгавруудыг «тийн ялгал»-ын нөхцөл мөн эсэх дээр эрдэмтэд нэгдсэн шийдэлд хараахан хүрээгүй байсаар. Ихэнх монгол хэлшинжээчид «тийн ялгал» гэж үздэг. Тухайлбал Академич Ш. Лувсанвандан “*Орчин цагийн монгол хэлний бүтэц*”² бүтээлдээ «нэрийн тийн ялгалын нөхцөл», Доктор М. Базаррагчаа “*Монгол хэлний нэрийн тийн ялгалын нөхцөлийн гарлын тухайд*”³ нэртэй эрдэм шинжилгээний өгүүлэлдээ «тийн ялгал», Доктор Ш.Барайшир “*Монгол хэлний гарахын тийн ялгалын тухай асуудалд*”⁴ нэртэй эрдэм шинжилгээний өгүүлэлдээ мөн «тийн ялгал», МУБИС-ийн МСС-аас эрхилэн гаргасан “*Орчин цагийн монгол хэл*”⁵ хамтын бүтээлдээ мөн «тийн ялгал» хэмээн тус тус дурджээ.

Харин Профессор Чой. Лувсанжав нарын зарим эрдэмтэд эл нэр томъёог дахин нягтлан судлах хэрэгтэй хэмээн бага сага өөр байр суурьтай байдаг. Энэ талаар түүний бичсэн “*Монгол хэлний тийн ялгалын тухай*” өгүүлэл дэх «1. Онолын хувьд хуучин уламжлалыг дагаж, судлалгүйгээр төвөдийн “тийн ялгал” хэмээгчийг даган хуулан хэрэглэж байгаад хожим Энэтхэг Европ хэлний мөн айг дуурайлгасан; 2. Хэлбэр судлал, бүтэцзүйн чанад зарчим баримтлаагүй; 3. Хэлбэр судлалд утга зүйг хольсон атал утга зүйн гол ялгаврыг гаргаагүй; 4. Өгүүлбэрзүйд үг найруулдаг гол үүргийг нь нарийвчлан судлалгүй “тийн ялгал” байна хэмээн зааж байгаа нь хэлшинжлэлийн бодитой нотолгоогүйг эрхбиш эргэж үзүүштэй»⁶ гэсэн дүгнэлтээс бэлхнээ мэдэж болохоор байна. Мөн түүнчлэн Профессор Ц.Шагдарсүрэн “*Монгол хэлний “тийн ялгал”-ын нэр томъёо, түүний гарлын асуудалд*”⁷ өгүүлэлдээ Профессор Чой.Лувсанжав эрдэмтний

1. Монгол Улсын Их Сургууль

2. Лувсанвандан.Ш. *Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг нөхцөл хоёр нь*. УБ. 1999. 39-р тал

3. Базаррагчаа.М. *Монгол хэлний нэрийн тийн ялгалын нөхцөлийн гарлын тухайд*. МУИС. ЭШБ. №8 (116). УБ. 1997

4. Барайшир.Ш. *Монгол хэлний гарахын тийн ялгалын тухай асуудалд*. МУИС. ЭШБ. Боть VI. №2 (13). УБ. 1962

5. МУБИС. *Орчин цагийн монгол хэл*. УБ 2004. 133-р тал

6. Лувсанжав.Чой. *Монгол хэлний тийн ялгалын тухай*. МУИС. ЭШБ. № 41. УБ. 1972

7. Шагдарсүрэн. Ц. *Монгол хэлний “тийн ялгал”-ын нэр томъёо, түүний гарлын асуудалд*. Acta Mongolica. Centre for Mongol Studies. NUM. Vol. 1 (182). УБ. 2002

Ц.Отгонсүрэн

санааг үргэлжлүүлэн, эл нэр томъёог гарлын нь хувьд нарийвчлан, монгол уламжлалт хэлзүйн бичгийг баримжаа болгож монгол, төвд, самгарди хэлний тийн ялгалыг харьцуулан судалж, бидний энд онцлон буй «-ТАI» бүтээврийг “Хамтрахын тийн ялгалын нөхцөл” хэмээн үзсээр ирсэн ч энэ нь уламжлалт монгол хэлзүйн бичгүүдэд орхигдсон талаар дурдаад, «...Орчин цагийн монгол хэлний зүйд уламжлал болсон -i/-yi нөхцөл бүхий Заахын тийн ялгал, -luɣa/-lüge нөхцөлтэй хамтрахын тийн ялгал бүрмөсөн орхигдсон ажээ. Учир нь монгол хэлний энэ хоёр тийн ялгалын утга илэрхийлэх нөхцөлтэй дүйдэг төвөд үг нь төвөд хэлэндээ тийн ялгалд хамаарагддаггүй болохоор Заах, Хамтрахын тийн ялгалыг тийн ялгал гэж тооцоогүй бололтой. Тэгээд ч “Зүрхэн толтын тайлбар”-т -i/-yi нөхцөлийг “Орхиц”, -luɣa/-lüge нөхцөлийг “Хураах үг” гэж тусгайлан нэрлэсэн байна»⁸ хэмээн бичжээ. Энэ нь ч аргагүй юм. Учир юу хэмээвээс энэхүү «-ТАI» бүтээвэр гэгч нь дундад үеийн Монгол хэлэнд «**тийн ялгалын нөхцөл**» бус харин нэр үгээс тэмдэг нэр үүсгэх «**дагавар**» байжээ. Энэ талаар олон судлаачид өөрсдийн судалгааны зохиол бүтээлд нэгэнт өгүүлснийг заримаас нь товчоолбол:

1. Японы нэрт эрдэмтэн, монгол судлаач, Профессор Ш.Озава «-ТАI», «-TU», «-TAN» бүтээврүүдийг хүйсээр ялгаж, тоо заадаг гэсэн саналыг анх дэвшүүлсэн. Өөрөөр хэлбэл тэрээр «-ТАI» бүтээвэр нь эм хүйсийг, «-TU» нь эр хүйст үгийг заах агаад «-TAN» нь олны утгыг илтгэдэг байжээ хэмээн үзжээ⁹.

2. БНХАУ-ын Өвөрмонголын эрдэмтэн Хасбагана дээрхи санааг улам лавшруулан судалж, «-ТАI» бүтээврийг нэр үгээс тэмдэг нэр үүсгэх «-TU» дагаврын эм хүйсийг илтгэх хэлбэр бөгөөд ингэж үүссэн үгнүүдийг харьцаа заасан тэмдэг нэр болно гэжээ¹⁰.

3. БНХАУ-ын Өвөрмонголын эрдэмтэн Норжин энэхүү «-ТАI» бүтээврийг хийсвэрлэх утгатай нэр үгээс уул нэр үгийн утгын дагуу хийсвэр шинж бүхий утгыг илэрхийлэх тэмдэг нэр үүсгэх дагавар хэмээгээд хамтрахын тийн ялгалын «-ТАI» нөхцлөөс хэрхэн ялгах талаар өгүүлжээ¹¹.

4. Монголын эрдэмтэн Ч.Алтанзагас мөн л тэмдэг нэрийн утгыг илэрхийлэх талаас орчин цагийн монгол хэлний «-ТАI» болон «-TU» бүтээврийн ялгааг тодорхойлон гаргажээ¹².

Энэ мэтээр тоочвол «-ТАI» бүтээврийг судалсан бүтээл нэлээд хэдийг дурдаж болохын зэргэцээ тэдгээр судалгаанаас үзвэл орчин цагийн монгол хэлэнд «хамтрахын тийн ялгал» гэгдээд байгаа «-ТАI» бүтээвэр нь дундад үеийн монгол хэлэнд нэрээс тэмдэг нэр үүсгэдэг дагавар байсан нь тодорхой байна.

Б. “Монголын Нууц Товчоо”-ны «-ТАI» бүтээврийг судлахын учир:

Дундад үеийн монгол хэлэнд нэр үгээс тэмдэг нэр үүсгэдэг байсан дагавар орчин цагийн монгол хэлэнд энэхүү утга, үүргээ хагас алдаж, “**хамтрахын тийн ялгалын нөхцөл**” гэгдэх болсноор монгол хэлний тийн ялгалын тухай маргаантай асуудлыг улам бүр эргэлзээнд хүргэх болсон. Тиймээс утгазүйн талаас чамгүй судалсан монгол хэлний «-ТАI» бүтээврийг бид “**өгүүлбэр дэх байр**”-аар үүргийн талаас нь судлахыг оролдлоо. Учир нь дээрхи асуудлаас гадна монгол хэлнээс гадаад хэл, гэр дундаа англи хэл рүү орчуулах даа зарим үед үгзүйн аргаар, зарим үед үгийн сангийн нэгжээр орчуулж, зарим үед өгүүлбэрзүйн аргыг ч хэрэглэдэг. Тухайлбал «**Морьтой хүн**» гэх хэлц ямартаа ч гурван өөр утгыг илэрхийлж, тэр хэрээр өөр өөр

8. Мөн тэнд. 68-69-р тал

9. Озава, Ш. *Монголын нууц товчооны ертөнц*. ОУМСХолбоо. “Дэлхийн Монгол судлалын дээжээс” Цуврал №4, 2002. Орчуулсан Б. Баярмэнд. 61-64-р тал

10. Хасбагана. *Дундад зууны монгол хэлний судлал*. Өвөрмонголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо. 1996. 321-322-р тал

11. Норжин. *Монгол хэлний үг бүтээх дагаврын жагсаалт*. “Монгол хэл бичиг” сэтгүүл. 1981. 53-р тал

12. Алтанзагас. *Ч.О морфеме “-ТАI” в монгольском языке*. МСДС. ЭШБ№9 (126). УБ. 1997

Ц.Отгонсүрэн

хувилбараар орчуулагдах боломжтой.

1. *Морь унаад явж буй хүн*-The man who is riding a horse;
2. *Морь малтай хүн*-The man who owns some horses;
3. *Аз хийморьтой хүн*-The man who is lucky.

Энэ мэт жишээ олныг дурдаж болохоор байна. Тиймээс энэхүү «-ТАI» бүтээврийн уг гарлыг судлах шаардлага зүй ёсоор гарч ирсэн тул бид дундад зууны үеийн монгол хэлний хэлний онцлогийг тусгасан, судалгааны чухал хэрэглэгдэхүүн болох “Монголын Нууц Товчоо” зохиолыг сонголоо. Цаашилбал эл зохиолыг гадаадын олон хэлээр тэр дундаа англи хэлээр хамгийн олон орчуулсантай холбогдуулан тэдгээр хувилбаруудаас орчуулах арга зарчим, тогтолцоо бий эсэхийг тандан судлах давхар ач холбогдолтой юм. Гэхдээ бид энэ удаад орчуулгын асуудлыг түр хойш тавьж, монгол хэлний онцлогийг түлхүү гаргахыг хичээлээ.

Нэг. “Монголын Нууц Товчоо” дахь «-ТАI» бүтээвэр

Эл зохиолыг анх монгол бичгээр тэмдэглэн, хожим хятад үсгээр сийрүүлсэн гэдэг санал дээр эрдэмтэд нэгдээд байна. Тиймээс дотоод, гадаадын олон нэртэй бичгийн мэргэд, эрдэмтэд, судлаачид тэрхүү хятад үсгээр тэмдэглэсэн эхийг гол баримтлан, галиглан буулгаж, орчин цагийн монгол хэл болон гадаадын хэд хэдэн хэлнээ орчуулан, судалгааны эргэлтэд оруулж, олны хүртээл болгосон билээ.

Харин бид эдгээрээс Австралийн монгол судлаач Игорь де Рахевилцийн галиг болох “*Index to the Secret History of the Mongols*”-дээр тулгуурлан, ажиглаж үзлээ.

Уг галигт «-ТАI» бүтээвэр 59 тохиолдсоныг бүртгэж авснаас «**өгүүлбэр дэх байр**»-аар нь мөшгивөл нэр үгийн өмнө-41, үйл үгийн өмнө-16, залгавар бүтээврийн өмнө-2 орсон байна. Одоо эдгээр утга, үүргийг өгүүлбэр дэх байраар нь дараах байдалтайгаар нарийвчилж болох юм.

А. Нэр үгийн өмнө тохиолдох байр:

Тэмдэг нэр гэдэг бол өгүүлбэрт нэр үгийн өмнө байрлаж, тухайн нэр үгээ тодотгох үндсэн үүрэгтэй. “Монголын Нууц Товчоо” зохиолд ч «-ТАI» бүтээвэр бүхий үгс тэмдэг нэр болохынхоо хувьд энэхүү үндсэн үүргээ хадгалж, нэр үг¹³-ийн өмнө хамгийн олон тохиолдсон нь харагдаж байна. Эдгээр тэмдэг нэрнүүд утгын хувьд хийсвэр болон бодит утгыг илэрхийлэх ч өгүүлбэрзүйн хувьд тухайн тодотгуулж буй нэр үгтэйгээ дараах байдлаар холбогдож байна. Үүнд:

1. Харьцаа заасан тэмдэг нэр: Энэ бүлгийн үгс «-ТАI» бүтээврээр үг хувилгаж, бодит утгыг илэрхийлснээр Ямар? гэсэн асуултанд хариулагдах хэдий ч гүн бүтцийн хувьд Юутай? гэсэн утгыг давхар агуулдаг. Ийм тэмдэг нэр харьцангуй олон буюу 33 удаа тохиолджээ. Тухайлбал:

8-р зүйлд: ... *barqujin-qo 'a-ca töre[k]sen alan-qo 'a neretei ökin tere.*

230-р зүйлд: *cinggis-qahan ügülerün e'ületei söni örügetei ger minu ...*

2. Харьцаа үл заасан тэмдэг нэр: Энэ нь дан гагц Ямар? гэсэн асуултад хариулагдаж, арын

13. Дашрамд дурдахад эл зохиолд нийт 41 «-ТАI» бүтээвэр бүхий үгс нэр үгийн өмнө тохиолдсон бөгөөд тэдгээр нэр үгнүүдийг ажиглаж үзвэл *tergen, okin, üjin, Alan-qo, gajar, eme, döyi, söni, ger, etügen, a'urasu* гэсэн цөөхөн хэдэн үг хэдэнтээ давтагджээ.

Ц.Отгонсүрэн

нэр үгтэйгээ харьцаа заахгүй, харин эл бүтээврээр хийсвэр утгыг илэрхийлсэн шинэ үг үүсгэжээ. Ийм тэмдэг нэр 8 удаа орсныг заримаас нь дурдвал:

54-р зүйлд: *e'ūsgejū ayisuqu-yi jolqaju ᠔nggeyijū ūje'esū ᠔ngge jisū **busitai** ᠔ki qatu ūjejū...*

111-р зүйлд: *... qunar mawu cilger hi **qutuqatai sutai** ūjin-i quriyaju iregū holun qotola merkit-e huntawu.*

Б. Үйл үгийн өмнө тохиолдох байр:

«-TAI» бүтээвр бүхий үгсийн өгүүлбэр дэх байраар нь нэлээд нягталмаар нэгэн зүйл бол энэхүү үйл үгийн өмнө тохиолдох байр гэж хэлж болно. Энэ нь орчин цагийн монгол хэлэнд энэхүү «-TAI» бүтээврийг “тийн ялгалын нөхцөл” гэж үзвэл холбогдож буй үйл үгс нь динамик шинжтэй байдагтай холбоотой юм. Гэтэл энд өгүүлж буй «-TAI» бүтээвр бүхий үгс нь тэмдэг нэр учраас үйл үгийн өмнө орохоороо буюу үйл үгтэй холбогдохоороо өгүүлбэрт гүйцэтгэх үүргийн хувьд онцлог байна. Ер нь аль ч хэлэнд үйл үг гэдэг бол өгүүлбэрт онцгой чухал үүрэгтэй ай учраас бид энэ хэсэгт өмнө нь дурдсанчилан тэмдэг нэрийг хийсвэр болон бодит утгатай гэхээсээ илүүтэйгээр ямар үйл үгтэй холбогдож, ямар үүрэг гүйцэтгэснийг чухалчиллаа. Эл зохиолд үйл үгийн өмнөх байранд 16 «-TAI» бүтээвр бүхий үг орсон бөгөөд, тэдгээртэй холбогдсон үйл үгийг ажиглаж үзвэл 13 нь холбоц үйл үг¹⁴, үлдсэн 3 нь динамик үйл үг байна.

1. Холбоц үйл үгийн өмнө орсон «-TAI» бүтээвр бүхий 13 үгийг бүртгэв. Ийм үйл үгийн онцлог гэвэл өмнөө орсон нэр үг болон тэмдэг нэртэй нийлж, нэгэн утга санааг илэрхийлж, нэг хэлц болсноор өгүүлэгдэхүүнтэй холбогдож, өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс эл зохиол дахь холбоц үйл үгийн өмнө орсон «-TAI» бүтээвр бүхий үгсийг дараах байдлаар хоёр хэсэгт хуваан үзэж болох юм.

- “a-” (*harbantai aju'u*; *yisūi neretei ...aji'ai-je* гэсэн 2 хэлбэр) болон “bū-” (*neretei būle'e*; *ke'elitei būrūn*; *᠔legetei būle'e*; *neretei būliyi*; *᠔legetei būkūi-ece* гэсэн 5 хэлбэр) язгуурт үйл үг уг зохиолд нийт 7 байна.

66-р зүйлд: *...nasun yeke **harbantai aju'u** hōrte neretei.*

155-р зүйлд: *... nadaca egeci yisūi **neretei** nadaca de'ere qan gū'ūn-e jokiqui **aji'ai-je**.*

59-р зүйлд: *... tende hō'elūn-ūjin **ke'elitei būrūn**...*

203-р зүйлд: *᠔gūle'e hi **᠔lege<i>tei būkūi-ece** ūndūr hosoqa-tur cinu ...*

- Үйл үгийн “тг” хувилбарын өмнө 6 оржээ. Өөрөөр хэлбэл холбоц үйл үгийн бүхий л үүргийг өмнөх тэмдэг нэрэнд шилжүүлж, тэрхүү холбоц үйл үгийг хураасан хэлбэр юм. Монгол хэл залгамал бүтэцтэйгээс гадна хийсвэрлэл ихтэй хэл учраас энэ мэтээр үг хураах үзэгдэл орчин цагийн монгол хэлэнд байхаас гадна дундад үеийн монгол хэлэнд ч байсны баталгаа болж байна.

146-р зүйлд: *usaqbasu tere eme gū'ūn ūgūlerūn sorqan-sira-yin ᠔kin hi qada'an **neretei**.*

14. Японы профессор, Ш. Озава “Auxiliary verb a-and bū- in Middle Mongolian (A study on the difference between their sememes)” өгүүлэлдээ «a-» болон «bū-» язгуурт үйл үгийг “туслах үйл үг” гэж томъёолсон нь үндсэн үйл үгийн ард туслах үүргээр хэрэглэгдсэнтэй холбоотой. Харин энд дурдаж буй эдгээр «a-» болон «bū-» язгуурт үйл үгийг “холбоц үйл үг” хэмээн томъёолсны учир гэвэл үүргийн хувьд дээрх томъёоллоос өөр буюу товч хэлбэл нэр үг болон тэмдэг нэрийн ард орсон үндсэн үйл үг хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл англи хэлний “to be”, “to become” зэрэг нэр үг болон тэмдэг нэрийг шаарддаг, тэдгээр үгнүүдтэй нийлж нэг утга санааг илэрхийлдэг “copular verb” буюу “linking verb” орчуулбал “холбоц үйл үг” болно.

Ц.Отгонсүрэн

71-р зүйлд: *uriju ülü ökteküi mörtei ci ucira'asu idegü yosutai ci ...*¹⁵

2. Динамик үйл үгэнд үйлдэл заасан үгнүүдийг хамааруулсан бөгөөд энэ байранд «-ТАI» бүтээвэр бүхий үгс эл зохиолд 2 байна. Эдгээр үгсийг тэмдэг нэр гэж үзэхэд учир дутагдалтай юм. Аль ч хэлэнд динамик үйл үг гэдэг нь бие даан утга илэрхийлж, өгүүлбэрт дангаараа өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэдэг учраас ийм үйл үгийн өмнө тэмдэг нэр орох байр байхгүй. Түүнээс гадна динамик үйл үгийг холбоц үйл үгийн нэгэн адилаар хураах буюу үүргийг нь бусад гишүүдэд шилжүүлэх боломжгүй юм.

- Хэлбэрийн хувьд тэмдэг нэртэй адил мэт боловч өгүүлбэрт гүйцэтгэх үүргийн хувьд өөр буюу “шинж чанар” заасан дайвар үг болж байгааг дараах жишээнээс харж болно.

74-р зүйлд: ...*sölsütei töreksen üjin eke sutan kö'üd-iyen teji'erün*....

- Харин нөгөө хоёр нь үйл үгтэй холбогдож тухайн үйлийн “байдал”-ыг зааж байна.

112-р зүйлд: *ger-tür inu belgütei bara'un e'üte(n)-ber oroqu-lu'a eke inu nabtarqai nekei de'eltei jewün e'üte(n)-ber qaru'at qadana busu gü'ün-ne ögülerün*....

244-р зүйлд “...*caqa'an teme'en köljü qara'utai tergetei söni-de dülin yorciju*...”

В. Залгавар бүтээврийн өмнө тохиолдох байр:

Эл зохиолын “229-р зүйлд: *mör mör-tür-iyen yabuju naran-u qaltai-a kebte'ül jayilaju*...”, “278-р зүйлд: *mör-dür-iyen yabuju naratai-a kebte'ül-e jayilaju* ...” гэсэн хоёр өгүүлбэр дэх *qaltai-a* болон *naratai-a* хэмээх хоёр үгийн ард салангид бичигдсэн “-а”-г нэг талаас оршихын тийн ялгалын нөхцөл, нөгөө талаас “аху-д”, “аху үед” гэсэн утгыг илэрхийлсэн “а-” язгуурын үйл үг гэж үзэж болмоор байна.

Магадгүй энэ хоёр хоорондоо холбоотой, өөрөөр хэлбэл оршихын тийн ялгалын нөхцөл нь “а-” язгуурт үйл үгийн утгыг шилжүүлж, хэлбэрийг нь хураасан хувилбар буюу эргээд “а-” язгуурт үйл үг нь оршихын тийн ялгалын нөхцлийн анхдагч байсан байж болох юм. Тиймээс энэ талаар гүнзгийрүүлэн судлууштай санагдана.

§ «-ТАI» бүтээвэр бүхий үгсийн хувьд нэгтгэн хэлбэл нэр үгийн өмнө хамгийн олон тохиолдож тэмдэг нэрийн үүрэгтэй орж байна. Гэхдээ холбоц үйл үгийн өмнө бас тохиолдож энэ үүргээ халгалахаас гадна бусад үйл үгийн өмнөх байранд орсноор дайвар үгийн үүрэг гүйцэтгэж байна.

Хоёр. “Монголын Нууц Товчоо” дахь «-ТАI» бүтээврийн хувилбарууд

Академиц Ш. Лувсанвандан “*Морфемын онолын тухай асуудалд*” өгүүлэлдээ бүтээврийн хувилбар мөн эсэхийг тогтоох гурван аргын талаар а. Адил утгатай эсэх; б. Бүтээвэр зүйтэй нөхцөлдсөн нөхөх байранд байгаа эсэх; в. Зэрэгцэн хэлбэржсэн бусад жишээ байгаа эсэхээр нь тус тус тогтоодог¹⁶ тухай бичжээ.

Дундад үеийн монгол хэлэнд «-ТАI» бүтээврийг эм хүйс, түүний хувилбар болох «-ТУ» бүтээврийг эр хүйс, харин «-ТАN» бүтээврийг олны утгыг тус тус илтгэдэг байжээ

15. Эл жишээнд гарч буй “сг” гэх үг нь утгаа үйлийн эзэн боловч өгүүлбэрийн эцэст орсон нь тухайн «-ТАI» бүтээвэр бүхий үгийг төлөөний нэрийн өмнө байрласан гэж ташаа үзэхэд хүргэж магад. Гэвч энэ бол өгүүлбэр дэх аль нэг гишүүнийг онцлохдоо байрыг нь өөрчилдөг хэлний тонгорох ёсны илрэл гэж үзэж болно.

16. Лувсанвандан. Ш. *Морфемын онолын тухай асуудалд*. Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган. IX боть. Хэлшинжлэлийн онолын асуудлууд. Улаанбаатар. 2010. 122-123-р тал

Ц.Отгонсүрэн

гэсэн саналыг Профессор Ш. Озава анх дэвшүүлэн гаргаснаас хойш ихэнх судлаачид энэ саналыг ерөнхийдөө баримталсаар ирсэн. Тэгвэл бид энэ хэсэгт “Монголын Нууц Товчоо”-нд тэмдэглэгдсэн «-TU» болон «-TAN» бүтээврийг «-TAI» бүтээврийн байранд тохиолдох эсэх дээр ажиглаж, тэдгээрийн хэлзүйн онцлогийг гаргахыг оролдлоо.

Юуны өмнө уг зохиолд тэмдэглэгдсэн дээрх бүтээврүүдийг тоон үзүүлэлтээр хүснэгтлэн үзүүлье.

Хүснэгт 1

№	Байр	Бүтээвэр		
		-TAI	-TU	-TAN
1	Нэр үгийн өмнө	41	78	61
2	Үйл үгийн өмнө	16	48	55
3	Залгавар бүтээврийн өмнө	2	6	24
4	Холбоосын өмнө	=	3	4
Нийт		59	135	144

«-TU» бүтээвэр

Энэхүү бүтээвэр нь угтаа дундад үеийн монгол хэлэнд нэр үгээс тэмдэг нэр үүсгэх эр хүйсийг заах дагавар байсан гэж үздэг. Тэгвэл “Монголын Нууц Товчоо” зохиолд энэхүү «-TU» бүтээвэр бүхий үг харьцангуй олон буюу 135 байхын зэргэцээ «-TAI» бүтээвэртэй адил утгыг илэрхийлэх ч тооны хувьд нэмэгдэхийн хэрээр өгүүлбэр дэх гүйцэтгэх үүрэг нь бас өөрчлөгджээ. (Хүснэгт 2-оос үзнэ үү)

А. Нэр үгийн өмнө тохиолдох байр:

Энэ байранд «-TU» бүтээвэр бүхий үг 78 буюу бусад байруудаас хамгийн олон тохиолдсон. Өмнөх «-TAI» бүтээврээс үүрэг хийгээд утгын хувьд ялгаагүй хэдий ч гагцхүү үйлийг гүйцэтгэж буй эзнээсээ хамааран бага сага зөрүүтэй байна.

1. Харьцаа заасан тэмдэг нэр: Энд «-TU» бүтээврээр үг хувилгасан нийт 46 тэмдэг нэрийг хамааруулав.

86-р зүйлд: ... *gürtele nigejijü qoyitu nunqasutu tergen-tür unuju ...*

91-р зүйлд: *niken caqa'an moritu gü'ün u'urqa hariju qaqa-'ar küvicejü ayisu ...*

2. Харьцаа үл заасан тэмдэг нэр: Энэ бүлэгт 31 «-TU» бүтээвэр бүхий шинээр үг үүсгэсэн тэмдэг нэрнүүдийг оруулав.

113-р зүйлд: *gücü nemekdejü erketü tenggiri-de nereyitcü eke etügen-e gürgejü*

149-р зүйлд: ... *tayici 'ud-un noyan tarqutai-kiriltuq hoilaju бүкүү yi östü gü'ün бүле 'e ke 'en morilan ülü cidaqu.*

Б. Үйл үгийн өмнө тохиолдох байр:

Энэ байранд «-TU» бүтээвэртэй холбогдох үйл үгийг үндсэнд нь 2 хэсэгт хувааж болох ч дотроо дэд хэсгүүдэд дахин задарч, ингэснээрээ «-TU» бүтээврийн үүрэг, хэрэглээг өргөтгөжээ.

Ц.Оггонсүрэн

1. Холбоц үйл үгийн ангилалд дараах 2 бүлэг үйл үгийг оруулсан хэдий ч үндсэн тэмдэг нэрийн үүрэг аль алинд нь хэвээрээ хадгалагдаж байна.

-«а-» болон «**bü-**» язгуурт үйл үгийн өмнө нийт 31 «-TU» бүтээвэр бүхий үг орсноос «**а-**» язгуурт үйл үг (гагц *aju* хэлбэр бүхий) 3. «**bü-**» язгуурт үйл үг (*büküi-tür, buyu, büle'e* гэсэн үндсэн 3 хэлбэр бүхий) 28 тохиолджээ. Эдгээр үйл үгнүүд үндсэндээ өмнөх үгтэй нийлж гол болон гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн болдог.

- Энд зөвхөн *aju* хэлбэр тохиолджээ.

3-р зүйлд: *qarcu-yin kö'ün hojigidai-mergen mongoljin qo'a gergeitü aju.*

147-р зүйлд: *nököceltü gü'ün buyu jirgo'adai neretü aju'u...*

- «**bü-**» язгуурт үйл үгээс *büle'e* хэлбэр нэлээд харин *buyu* хэлбэр цөөн атугай тохиолдож байна.

145-р зүйлд: *odurun ker ber hariqda'asu hi dan-tur oroqu duratu büle'e.*

160-р зүйлд: *uridaca naiman-tur elcütü büle'e...*

Бас нэгэн онцлог зүйл гэвэл *büküi-tür* гэх хэлбэр нь *nasutu* гэх үгэнд хэдэнтээ давтагдсанаас үзвэл цаг заасан утгыг илтгэж байна. Тухайлбал: 60-р зүйлд: ... *temüjin yisin nasutu hülküi-tür joci-qasar dolo'an nasutu büle'e* гэх мэт.

-«**holo-**» язгуурт үйл үг нь эл зохиолд «-TU» бүтээвэр бүхий үгийн ард 7 удаа тэмдэглэгдсэнийг ажиглаж үзвэл мөн л тэмдэг нэрийн шинжтэй байна. Учир нь энэхүү «-TU» бүтээвэр бүхий үг тухайн өгүүлбэр дэх үйлийн эзний шинжийг заах гул тэрхүү үйлийн эзнийг давтахгүйн тулд арын нэр үгийг хураажээ гэж үзэх боломжтой.

121-р зүйлд: *qo'aqcin üni'en ...jamuqa-yi ürgüjü öre'ele eber-iyen ququraju so[l]jir ebertü bolju...*

164-р зүйлд: *basu ong-qan ügülerün ... temüjin kö'ün-i senggüm-ün aqa bolqaju qoyar kö'ütü bolju amusuqai ke'ejü...*

2. Динамик үйл үгийн ангилалд дараах 2 бүлэг үйл үгийг оруулав.

- «**ke-**» язгуурт үйл үг эл зохиолд 1 удаа дараах хэлц дэх 2 үгэнд холбогдон оржээ. 82-р зүйлд: *eyimü arqatu-yin tula nidün-dür-iyen qaltu ni'ur-tur-iyen geretü ke'en tayici'ut aqa de'ü-de'en teyin ele naitaqdan aju'u.*

- Бусад үйл үгийн бүлэгт *jaya'atu töreksen: beye teri'ütü de'el jaqatu sayin: moritu horumlaju. doto'ajitu güyijü. abirtu yabuju. moritu yadaju. moritu ireba. degeltü döröksen* гэсэн үгнүүдийг хамааруулснаас «-TU» бүтээвэр бүхий үгнүүд цөм тухайн үйлийн байдлыг заасан дайвар үгийн үүрэгтэй байна.

145-р зүйлд: *Jelme qaqa doto'ajitu curama nicügün sitüldüjü bayiqun dayin dотора'un güyijü.*

177-р зүйлд: ...*teme'en-ü cisun qanaju idejü qaqa soqor qali'un moritu ireba-je...*

В. Залгавар бүтээврийн өмнө тохиолдох байр:

Өмнөх «-TAI» бүтээвэр бүхий үгс дан гагц “-а” залгавар бүтээврийн өмнө тохиолдсон бол энэхүү «-TU» бүтээвэр бүхий үгс дараах хоёр залгавар бүтээврийн өмнө орсноороо «-TAI»

Ц.Отгонсүрэн

бүтээврээс үүргийн хувьд харьцангуй ялгаатай болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл нэр үгийг тодотгодог тэмдэг нэрийн үүргээс гадна өгүүлбэрт бие даасан нэр үг болж байгаагаараа ихээхэн онцлог юм.

1. **-yi/-i** залгавар бүтээврийн өмнө «-TU» бүтээвэр бүхий үг 5 орсон байна. Нэгэнтээ эдгээр үгс нь өөрөө **-yi/-i** залгавар бүтээврээр хэлбэржсэн учраас өгүүлбэрт шууд тусгагдахуун болж, үйл үгтэй холбогджээ.

139-р зүйлд: ... *omoqtan irgen-i cinggis-qahan dorayita 'ulju jürkin **oboqtu-yi** ülitkeba...*

2. **-yin** залгавар бүтээврийн өмнө «-TU» бүтээвэр бүхий үг 1 байх бөгөөд энэ нь мөн л нэр үгийн үүргийг дангаараа гүйцэтгэж байгаагаараа «-TAI» бүтээврээс ялгаатайн дээр бас нэгэн онцлох зүйл гэвэл **-yin** залгавар бүтээвэр нь орчин цагийн монгол хэлэнд ардаа орсон нэр үгийг өмнөх үгэнд хамааруулж, харьяалуулдаг бол энд өмнөх «-TU» бүтээвэр бүхий үгээ илүү онцолсон үүрэгтэй байна.

82-р зүйлд: *eyimü **arqatu-yin** tula nidün-dür-iyen qaltu ni 'ur-tur-iyen geretü ke 'en tayici 'ul aqa de 'ü-de 'en teyin ele naitaqdan aju 'u.*

Г. Холбоосын өмнө тохиолдох байр:

Аль ч хэлэнд үг хийгээд өгүүлбэрүүдийг хооронд нь холбох үүрэгтэй нэгж бол холбоос юм. Ялангуяа гишүүн өгүүлбэрийн хувьд холбоос нь бүтэн өгүүлбэр хийгээд тухайн өгүүлбэрийн санааг бүрэн илэрхийлэхүйц нэр үг болон нэрийн хэлцийг гол өгүүлбэртэй нь холбодог. Тиймээс эл байранд «-TU» бүтээвэр бүхий үг орсноороо нэр үгийн үүрэг гүйцэтгэх болж уу эсвэл арын нэр үгийг хураасан уу гэсэн асуулт гарч ирнэ.

1. **bö'etele** холбоосын өмнө «-TU» бүтээвэр бүхий 1 үг хоёронтоо оржээ.

111-р зүйлд: ... *qara kere 'e qalisu körisü idegü **jaya'atu bö'etele** qalawun toqora 'un-i idesü ke 'en jesin aju 'u; ... quladu mawu sibawun quluqana kücügene idegü **jayatu bö'etele** qun toqura 'un-i idesü ke 'en jesin aju 'u...*

2. **tula** холбоосын өмнө тохиолдох байр ихээхэн өвөрмөц аж. Эл байранд «-TU» бүтээвэр бүхий үг 2 удаа орсны нэг нь шууд, нөгөө нь **-yin** залгавар бүтээвэртэй хамт орсныг өмнөх хэсэгт өгүүлсэн билээ. «-TAI» бүтээврийн хувьд орчин цагийн монгол хэлэнд холбоосын өмнө тохиолдох ч дундад үеийн монгол хэлний онцлогийг тусгасан “Монголын Нууц Товчоо”-д тэмдэглэгдээгүйг дашрамд дурдалтай.

46-р зүйлд: *noyamsik **abirtu tula** noyakin oboqtan bol(tu)ba.*

§§ «-TU» бүтээвэр бүхий үгийн хувьд нэгтгэн хэлбэл нэр үг, холбоц үйл үгийн өмнө хамгийн олон тохиолдсоноороо тэмдэг нэрийн үүрэг илүү давамгай болохыг харуулахын зэргэцээ бусад байранд мэр сэр тохиолдож нэр үг болон дайвар үгийн үүрэг гүйцэтгэж байгааг ч бас тэмдэглэмээр байна.

«-TAN» бүтээвэр

«-TAN» бүтээвэр нь дундад үеийн монгол хэлэнд «-TAI» бүтээврийн олон тоог зааж байсан гэж үзсээр ирсэн. Ийм бүтээвэр бүхий үг “Монголын Нууц Товчоо” зохиолд хамгийн олон буюу нийт 144 удаа тохиолдсоныг өгүүлбэр дэх байраар нь судалж үзвэл дараах хэдэн онцлогтой байна.

А. Нэр үгийн өмнө тохиолдох байр:

Энэ байранд «-TAN» бүтээвэр бүхий үгс нийт 61 бүртгэсэнээ ажиглаж үзвэл 2 үндсэн хэсэгт ангилж болно.

Ц.Отгонсүрэн

1. Олны утгыг илэрхийлсэн үгс: Эрдэмтдийн илэрхийлэн гаргаснаас үзвэл дундад үеийн монгол хэлэнд «-TAN» бүтээвэр нь нэрээс тэмдэг нэр үүсгэдэг, олны утгыг илэрхийлсэн дагавар байсан нь эл зохиолд тод илэрчээ. Хэдийгээр тэдгээр үгнүүд олны санааг илэрхийлсэн ч өгүүлбэрт гүйцэтгэх үүргээрээ бага зэрэг зөрүүтэй байна. Үүнд:

- Харьцаа заасан: Энэ бүлэгт нийт 31 үг байх агаад шинээр үг үүсгээгүй гагцхүү үг хувилгасан «-TAN» бүтээвэр бүхий тэмдэг нэрнүүд цөм олон тоот нэр үгийн өмнө орсныг дараах жишээнээс харж болно.

262-р зүйлд: ...*irgen-tür gürtele idil jayaq usutan müret ketülün...*

266-р зүйлд: ...*terme gertenteme 'en aciatantang 'udud-i ceri 'üt ilzjü...*

- Харьцаа үл заасан: Энэ бүлэгт 20 үгийг хамруулсан бөгөөд учир нь тухайн тэмдэг нэр бүгд шинээр үг үүсгэжээ. Мөн **irgen, kebte'ül** гэсэн 2 үг хэдэнтээ давтагдаж, олон тооны нөхцөл аваагүй нь тухайн хүмүүсийг бүхэлд нь хамруулж байгаатай холбоотой аж. Хэрвээ олон тооны нөхцөл давхар авбал монгол хэлний тоогоор зохицох ёсны дагуу «бүгд, бүх хүмүүс» гэсэн утгыг илэрхийлж чадахгүй, зөвхөн хэсэг бүлэг хүмүүсийг заана. Харин **ina'ut** гэх үг олны утгыг илэрхийлсэн нөхцөл авч, хэсэг бүлэг хүмүүсийг заасан нь үүний илрэл болж байна. Эдгээр онцлогуудыг дараах хэдэн жишээнээс харж болно

214-р зүйлд: *basa ebüges ecige-i baraqsat östen kišten tatar irgen-i dorai da 'ulju...*

230-р зүйлд: *oron dотора ese oqjatqaqsan öljeitan kebte ül minu; jirüge amu 'uluqsan cing setkilten kebte 'ül minu.*

266-р зүйлд: ...*altan-qan-mu itegelten ina 'ut...*

- 2. Хүндэтгэлийн утгыг илэрхийлсэн үгс: Эдгээр үгс харьцангуй цөөн буюу 10 байгааг ажиглаж үзвэл бүлэг хүн, амьтан, юмс үзэгдлийн дотроос хэн нэгэн, аль нэгийг нь онцгойлон тодотгож, хүндэтгэсэн утгыг илтгэжээ.

122-р зүйлд: *qunan teri 'üten geniges niken güre 'en ireba-gü*

205-р зүйлд: ... *ücügen caq-tur sirqa agta-tan naiman morit de 'ermettejü ja 'ura...*

Б. Үйл үгийн өмнө тохиолдох байр:

Энэ байранд байх «-TAN» бүтээвэр бүхий үгийг мөн л хоёр хэсэгт хувааж болно.

- 1. Холбоц үйл үг нь үндсэн 2 бүлэг үгс байна. Үүнд:

- «**hü-**» язгуурт үйл үгийн өмнө нийт 9 тохиолдсоноос **büle'e, hüle-ei, bui, bui-je** гэсэн 4 хэлбэр давтагдсан нь хоорондоо утга хийгээд үүргийн хувьд төдий л ялгарах зүйлгүй. Харин энэ хэсэгт тэмдэглэвэл зохих нэгэн зүйл гэвэл «**а-**» язгуурт үйл үг тохиолдоогүй.

189-р зүйлд: ...*mongqol irgen hümür mawutan qubcasu baratutan бүле 'ei...*

193-р зүйлд: ...*hodun-naca olon galtan bui ke 'en...*

249-р зүйлд: ... *gücü ögürün nunji nuntuqan nödüksen balaqasutan bui-je...*

- «**holo-**» язгуурт үйл үгийн өмнө 21 «-TAN» бүтээвэр бүхий үг орсныг «-TU» бүтээврийн нэгэн адилаар үйлийн эзнийг нь хураасан тэмдэг нэр гэж үзэж болно.

47-р зүйлд: *caraqai-lingqu-yin kö'ün senggüm-bilge ambaqai-tan tayici 'ut oboqan hol<u>ba.*

Ц.Отгонсүрэн

Гэхдээ тухайн үйлийн эзнийг биш өөр биеийг зааж буй газар бас байгааг анзаарахгүй өнгөрч болохгүй юм. Энэ тохиолдолд тухайн өгүүлбэрийн үйлийн эзнийг хураажээ гэжээсээ илүүтэй дангаараа нэр үгийн үүргийг гүйцэтгэж байна гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл эл бүтээвэр «**bolo-**» язгуурт үйл үгийн өмнө орохоороо дундын шинжтэй болж байна. Тухайлбал:

187-р зүйлд: *basa cinggis-qahan jarliq holurun ... ongqojit-kereyid-i **kesikten** anu boltuqai...*

2. Динамик үйл үг нь нэгэнтээ үйлдэл заасан үгнүүд, мөн энэ бүтээврийг«-ТАI» бүтээврийн нэгэн хувилбар хэмээн үзэж байгаа тул 2 бүлэг үйл үгийг хамааруулав. Үүнд:

- «**ke-**» язгуурт үйл үгийн **keke**, **ke'emüi**, **ke'ejü**, **ke'ekdemüi** гэсэн 4 хэлбэрийн өмнө эл бүтээвэр бүхий үгс 4 удаа оржээ.

121-р зүйлд: *...jamuqa-lu'a ke'eli **niketen keke qaqacatan hüle 'e ba...*** Энэ жишээнд гарсан **keke** хэмээх үг нь тодотгол гишүүн өгүүлбэрийн холбоосын үүрэгтэй байна.

270...*irgen ted emeses **qurcatan ke'ekdemüi ke'ejü...***

- Бусад үйл үг гэсэн бүлэгт хамааруулах ***megüjin-se'ültü-ten eye-düriyen ülü oroqatarun: kesikten **bawurci; manglaitan, qosi'utan, keleten, öreten, mina'atan si'üder idejü; muqali-tan ...tusa kile'e; keleten ire'esü; kesikten ci'ulasu***** гэх мэт нийт 21 үг байгааг ажиглаж үзвэл «-ТАN» бүтээвэр бүхий үг цөм нэр үг болж өгүүлбэрт өгүүлэгдэхүүний үүрэгтэй байна. Тухайлбал: 229-р зүйлд: *...ya'aral **keleten haran söni ire'esü kehte'ül-tür kelelejü...***

279-р зүйлд: *aqa de'ü olon ere aqta **kesikten ci'ula'asu...***

В. Залгавар бүтээврийн өмнө тохиолдох байр:

Энэхүү байранд«-ТАN» бүтээвэр орсон нь эл бүтээвэр бүхий үгийг нэр үг болгож байна. Эдгээр залгавар бүтээвэр бүхий үг 23 удаа орсныг ерөнхийлөн үзвэл 4 төрлийн залгавар бүтээвэр байна. Үүнд:

1. **-yi/-i** залгавар бүтээвэр хамгийн их буюу 16 удаа тохиолджээ. **-yi/-i** залгавар бүтээврийг нэр үгэнд залгаж, тухайн нэр үгээ шууд тусалдахууны үүргээр үйл үгтэй нь шууд холбодог.

154-р зүйлд: *qudal **üviletен-i jarqulatuqai...***

203-р зүйлд: *...isegei **tu'urqatan-i irice'üljü qabdasun e'üdeten-i qaqaca'ulju qubilaju...***

Энд бас **-yi/-i** бүтээврийн тэг хувилбараар хэлбэржсэн хэд хэдэн «-ТАN» бүтээвэр бүхий үг байгааг дурдах хэрэгтэй.

191-р зүйлд: *... gü'ün-ü kö'üd-i de'ü-ner-i oro'ulurun **erdemüültten beye sil savitan ilqaju...***

2. **-yin/-un** бүтээврийн өмнө «-ТАN» бүтээвэр бүхий үг 3 тохиолдсон нь нэр үгийн үүрэгтэй болохыг харуулж байна.

278-р зүйлд: *... harbad-un noyad-aca minu **kesikten-ü kötöcin de'ere bui-je...***

3. **-a/-e** бүтээврийн өмнө «-ТАN» бүтээвэр бүхий үг 3 орсон нь хандах утгыг илэрхийлжээ. 170-р зүйлд: *... dergede'ün hükün **itegelten-e kelen.***

4. **-tur/-tür** бүтээврийн өмнө «-ТАN» бүтээвэр бүхий үг 3 орсон харилцан үйлдэлцэх утгыг илэрхийлэхэд голлох үүрэг гүйцэтгэжээ.

278-р зүйлд: *... qadanadus minqali'ut minu **kesikten-tür kereldü'esü...***

Ц.Отгонсүрэн

Г. Холбоосын өмнө тохиолдох байр:

Эл байранд **bö'esü** (4) хэмээх болзол заасан утга бүхий холбоос нийт 4 удаа тохиолдсон. Ажиглаваас энэ байранд байх «-TAN» бүтээвэр бүхий үг өгүүлбэрийн үүрэг бүхий нэр үг буюу нэрийн хэлцээр илэрчээ. Тухайлбал:

227-р зүйлд: ... mökōriülkūn vosutan bö'esü bida mökōri'ülū-je.

§§§ «-TAN» бүтээвэр бүхий үгийн хувьд нэгтгэн хэлбэл нэр үгийн өмнөх байранд тэмдэг нэр, бусад байранд нэр үг болж байна. Тэгэхээр нэр үгийн үүрэг гүйцэтгэх чадамж нь өмнөх 2 бүтээврээс илүү давамгайл байгааг дараах хүснэгт (2)-оос харж болно.

Хүснэгт 2

Байр	Онцлог	++-TAI	-TU	-TAN
Нэр үгийн өмнө	Харьцаа заасан	33	46	31/51
	Харьцаа үл заасан	8	31	20/51
	Олны утга илэрхийлсэн	=	=	51'
	Хүндэтгэл илэрхийлсэн	=	=	10
	Тэг хувилбар	=	1	=
Нийт		41	78	61
Үйл үгийн өмнө	A-	2	3	=
	Bü-	5	28	9
	Тэг хувилбар	6	=	=
	Bolo-	=	7	21
	Ke'e-	=	2	4
	Бусад	2	9	21
Нийт		15	49	55
Залгавар бүтээврийн өмнө	-yi/-i	=	5	15
	-yin/-un	=	1	3
	-a/-e	2	=	3
	-tur/-tūr	=	=	3
Нийт		2	6	24
Холбоосын өмнө	Bö'esü	=	=	4
	Bö'etele	=	2	=
	Tula	=	1	=
Нийт		=	3	4
БҮГД		58	136	144

ДУГНЭЛТ

Бид энэ өгүүллээрээ монгол хэлний «-TAI» бүтээвэр нь «тийн ялгал»-ын нөхцөл үү, аль эсвэл өөр нэгэн бие даасан залгавар уу гэх асуудлыг шийдвэрлэх гэсэн хэрэг бус харин уг бүтээвэр болон түүний хувилбаруудыг XIII-XIV зууны үеийн монголын эртний түүх, уран зохиолын дурсгал бичиг болох “Монголын Нууц Товчоо”-нд хэрхэн тэмдэглэсэн хийгээд дундад үеийн монгол хэлэн дэх тэдгээрийн утга, үүрэг, хэлзүйн онцлогийг гаргахыг зорьж, тодорхой хэмжээнд судалгаа хийж дараах хэдэн дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

1. Дундад үеийн монгол хэлэнд хүйс, тоогоор зохицох ёс байсны нэг илрэл нь энд бидний дурдсан «-TAI», «-TU», «-TAN» бүтээврүүд бөгөөд эдгээр нь хүйс, тооны ялгааг эс тооцвол Академич Ш. Лувсанванданы тодорхойлсон, дээр дурдсан гурван аргад яв цав нийцэж буй тул нэг дагаврын хувилбарууд гэж үзэх бүрэн боломжтой.
2. Энэ зохиолын сонгомол эх¹⁷-эд «-TAI» бүтээвэр харьцангуй олон, бусад хувилбарууд нь цөөн, харин Рахевилцын “Галиг”-т эсрэгээрээ «-TAI» бүтээвэр харьцангуй цөөн «-TU» болон «-TAN» бүтээвэр олон тэмдэглэгдсэнээс үзвэл нэг талаасаа орчин цагийн монгол хэлэнд «-TAI» бүтээврийг илүүтэй хэрэглэх болжээ гэж үзэх буюу нөгөө талаасаа энэ нь хэлний хувьсал хөгжлийг харуулжээ гэлтэй. Өөрөөр хэлбэл энд онцлон буй гурван бүтээврийн хувьслын шалтгааныг өгүүлбэр дэх байраар нь ерөнхийлөн тайлбарлавал:
 - «-TAI» бүтээврийн хувьд харьцаа заасан үүрэг бүхий бодиг утга нь шилжсэнээр орчин цагийн монгол хэлэнд хамграхын утга илэрхийлэх бүтээвэр болж хувирсан.
 - «-TU» бүтээврийн хувьд тэмдэг нэрийн үүрэг харьцангуй давамгай байгаагаас энэ шинжээ өнөөг хүртэл хадгалсаар ирсэн.
 - «-TAN» бүтээврийн хувьд тэмдэг нэрээс гадна нэр үгийн үүргийг илүүтэй гүйцэтгэж байсан нь орчин цагийн монгол хэлэнд нэр үг үүсгэх дагавар болж хувирахын эхлэл, үндэс суурь болжээ хэмээн тус тус үзэж болох юм.
3. Дундад үеийн монгол хэлний хүйсээр зохицох ёсны илрэл болгож, «-TAI», «-TU», «-TAN» бүтээврүүдээр дамжуулан тухайн өгүүлбэр дэх үйлийн эзнийг тогтоох боломжтой аж. 94-р зүйлд: «*tendece temüjin be[ll]gütei qoyar dei-secen-nü hörte-üjin-i yisün nasutu hūküi-tür ijējū irekse'er qaqacaju hūle'e*» гэсэн өгүүлбэрийг ганц удаа уншиж үзсэн хүн эсвэл монгол хэлэнд сайн нэвтрээгүй хүмүүст есөн настай хүн нь Бөртэ мэтээр ойлгогдохоор байна. Гэтэл угтаа nasutu гэдэг үгийн **-tu** төгсгөл нь эр хүйсийг заадаг учраас түүнээс улбаалан тэр есөн настай хүн нь Тэмүүжин гэдгийг учир зүйн үүднээс ухаж ойлгож болно.

17. Энэ бүтээвэр нь олны утгыг илэрхийлсэн хэдий ч дотор нь задалж үзвэл харьцаа заасан (31/51) хийгээд үл заасан (20/51) үүрэг гүйцэтгэж байгаа тул тоог нь давхар тэмдэглэв.

18. «Монголын Нууц Товчоо»-ны сонгомол эх. Болор судар хэвлэлийн газар, Улаанбаатар, 2009.

Ц.Отгонсүрэн

4. “Галиг”-аас үзвэл эл зохиолд «-ТАI» бүтээвэр бүхий үг цөөхөн харин «-TU» болон «-TAN» бүтээвэр бүхий үг харьцангуй олон байгааг тухайн үед «-ТАI» бүтээврийг цөөхөн харин «-TU» болон «-TAN» бүтээврийг нэлээд түлхүү хэрэглэдэг байжээ хэмээн ганцхан зохиол дээр тулгуурлан дүгнэх нь хам цагийн үүднээс авч үзвэл хэтэрхий өрөөсгөл болох мэт. Харин түүний оронд эдгээр бүтээврүүдээр дамжуулан эл зохиолыг баатар эрс болон дайн байлдаан, нийт олныг түлхүү өгүүлсэн буюу ерөнхийдөө «АРГА» шинж давамгайлсан зохиол гэж үзэж болохоор байна.

5. «-ТАI», «-TU», «-TAN» бүтээврүүд нь хүйс, тоог заадаг гэж үздэг ч гэдгээрийг тодорхойлох арга нь тухайн тэмдэг нэрийн ард тодотгуулж буй нэр үг бус харин тухайн үйлийг гүйцэтгэх эзнээс хамааралтай биш байгаа гэсэн саналыг дэвшүүлж байна.

АШИГЛАСАН НОМ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. Алтанзагас. Ч. *О морфеме "-ТАЙ" в монгольском языке*. МСДС. ЭШБ№9 (126). Улаанбаатар. 1997
2. Francis Woodman Cleaves. *The Secret History of the Mongols*. Volume I. (Translation). Harvard University Press. USA. 1982.
3. Igor de Rachewiltz. *Index to the Secret History of the Mongols*. Indiana University. Bloomington. 1972.
4. Ким Хагсон. *Монголын Нууц Товчоо болон Manyoosuu-гийн тийн ялгалын харьцуулсан судалгаа*. Докторын диссертаци. Улаанбаатар. 2002
5. Лувсанвандан. Ш. *Морфемын онолын тухай асуудалд*. Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган. IX боть. Хэлшинжлэлийн онолын асуудлууд. Улаанбаатар. 2010
6. Лувсанвандан. Ш. *Орчин цагийн монгол хэлний бүтэц*. Дэд дэвтэр. Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь. Улаанбаатар. 1999
7. Лувсанжав. Чой. *Монгол хэлний тийн ялгалын тухай*. МУИС. ЭШБ. № 41. Улаанбаатар. 1972
8. *ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠵᠢᠭᠠᠯᠠ ᠲᠤᠬᠤᠨ*. «*ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠢᠨ ᠵᠢᠭᠠᠯᠠ*» ᠮᠣᠩᠭᠣᠯ. ᠑᠙᠘᠑
9. Саруул-Эрдэнэ.М. *Монгол хэлний нөхцөл бүтээврийн үгзүйн түүхэн хувьсал*. Докторын диссертаци. Улаанбаатар. 2002
10. Shigeo Ozawa. *Auxiliary verb a- and hü- in Middle Mongolian*. (Study on the difference between their sememes). 東京外国語大学論集 1 2. Tokyo. 1965.
11. Озава. Ш. *Монголын нууц товчооны ертөнц*. ОУМСХолбоо. "Дэлхийн Монгол судлалын дээжээс" Цуврал №4. Орчуулсан Б. Баярмэнд. Улаанбаатар. 2002
12. Shigeo Ozawa. 元朝秘史蒙古語文法論議. 風間書房. 東京. 平成 5 年 (1993)
13. Төмөртоогоо. Д. *Монгол хэлшинжлэлийн онол, түүхийн асуудлууд*. Улаанбаатар. 2002
14. *ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠢᠨ ᠵᠢᠭᠠᠯᠠ ᠲᠤᠬᠤᠨ*. «*ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠢᠨ ᠵᠢᠭᠠᠯᠠ*» ᠮᠣᠩᠭᠣᠯ. ᠑᠙᠙᠙
15. Цэрэнпил. Д. *Орчин цагийн монгол хэлний харьцал бүтээврийн бүтэц-үүргийн тогтолцоо*. Докторын диссертаци. Улаанбаатар. 1997
16. Чоймаа. Ш. *Монгол түүхэн сурвалжийн эх бичгийн харьцуулсан судалгаа*. Докторын диссертаци. Улаанбаатар. 2004
17. Шагдарсүрэн. Ц. *Монгол хэлний "тийн ялгал"-ын нэр томъёо, түүний гарлын асуудалд*. Acta Mongolica. Centre for Mongol Studies. NUM. Vol. 1 (182). Улаанбаатар. 2002

Ц.Отгонсүрэн

ABSTRACT

Through this article, we attempted to study «-TAI» morpheme, that is described to be the affix of comitative case in Modern Mongolian, and its variants «-TU» as only a function and «-TAN» as a form and function, based on "the Secret History of the Mongols", which is the most important source materials of Middle Mongolian.

In accordance with our studies, the «-IAI» morpheme and its variants have the same nature as adjectives, precede any noun. However, other distributions of all three morphemes, occurred in sentences, reveal their different functions. For example, as for the ones before verb, they can still be adjective if the verb is copular, but adverb if the verb is dynamic. And the ones before preposition as well as conjunction, make them nouns.

In addition to them, the «-TAI» morpheme has been turned into the affix of comitative case, caused by its inflectional function, while the «-TU» has still been kept its derivational function and become the suffix to derive adjective in Modern Mongolian. Also, the «-TAN» morpheme has more special functions as noun than adjective in all the distributions, although it is pointed to be the plural form of adjective in the Middle Mongolian, so that, it has become the suffix to derive noun from noun in Modern Mongolian.